

Кассын програм суулгасан компьютер дээр тухайн дэлгүүрийн барааны мэдээлэл агуулагдаж байгаа файлыг хадгалж авдаг програм давхар ажилладаг. Энэ програм нь ажиллахдаа хар дэлгэц дээр цагаан бичиг гарч ажилладаг. Хэрэв тухайн кассын компьютерийн хурд удаан байвал энэ програм удаан ажиллаж кассын кассын программын ажиллагааг удаадаг. Үүнийг кассын програм гацлаа гэж ойлгодог. Энэ тохиолдолд тухайн хар дэлгэц дээр цагаан бичиг гарч ажиллаж байгаа програмыг ажиллаж дуустал нь хүлээх хэрэгтэй. Энэ програмыг хүчээр зогсоож болохгүй.